

Дурсамж


МУИС-тай холбогдсон миний амьдрал

МУИС-ийн 80 жилийн ойд...

Монгол улсын их сургууль (МУИС) бол манай орны анхны бөгөөд үндэсний хэмжээний Их сургууль-University-Университет. Энэ сургууль найман аравны өмнө байгуулагдаж, анхны ректороор нь бидний нэгэн авга гэж тооцогддог Түнжингийн Машлай гэдэг хүн Ардын Гэгээрлийн сайдын албыг хашихын зэрэгцээ хавсран ажиллаж байсан. Энэ л гал голомтоос өнөөгийн АШУИС, ХААИС, ШУТИС туурга тусгаарлаж, торнин хөгжсөн түүхтэй.

Миний бие УДТДМБХ-ны 143 тоот томилолт, МУИС-ийн Ректорын 400-р тушаалаар 1975-6-16-наас багшаар ажиллах болсноо энэ амьдралын минь их хувь заяа гэж насан турш сүсэглэн

дээдлэж, эгэл жирийн инженерээс багш гэж тооцогдох болж, эдүүгээ Монгол улсын Гавъяат багш хэмээх эрхэм алдар цолыг хүртлээ. Намайг багш болох үед МУИС-ийн Ректороор академич Н.Содном багш, Сургалт эрхэлсэн проректороор Лхамсүрэн багш, Эдийн засаг санхүү эрхэлсэн проектороор Миеэгомбо гуай, Боловсон хүчнээр Хуушаан гуай, Ерөнхий санхүүчээр Доржпалам гуай, ПДС хариуцсан захирлаар эхлээд Б.Лувсанцэрэн гуай, улмаар удаан хугацаанд эдүүгээ Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Академич Ч.Авдай багш маань ажиллаж ирсэн юм.



Манайхан, 1979 онд. Зүүн гараас, анхны маань тэнхимийн эрхлэгч **Б.Ишмэнд**, декан **А.Самдан**, өрмийн багш **Ж.Цэвээнжав**, өрмийн зөвлөх багш **В.А.Яковлев**, өрмийн сургалтын мастер **Б.Тодя**, өрмийн сургалтын мастер **Д.Должин**

Тэр жил МУИС-д шинээр надтай нэгэн сургуулийн анд **С.Цэдэндорж**, математикийн багш **Дарьсүрэн**, хожмоо Монголын төр, нийгмийн томоохон зүтгэлтэн **Р.Гончигдорж**, гавъяат багш **Баянсан**, **С.Дулам** нарын зэрэг 16 хүн багш болж, нөгөө 15 хүний тушаал 1975-7-1-нээс гарч байсан болно. Учир юу вэ? гэвээс миний бие тухайн үеийн ГУУЯ-ны нэр дээр, тэдний зардлаар сурсан, яамнаас намайг

Цагаансуврагын экспедицид Өрмийн инженерээр хуваарлиж байсан бөгөөд яамнаас орлогч сайд байсан, хожмоо эрдэмтэн геологич, эдүүгээ Монгол улсын Хөдөлмөрийн баатар, эрхэм дотнын хүн **Ч.Хурц** гуай маань болон яамныхан хөөцөлдөн чаргуулагдаж байсан боловч эх орондоо Өрмийн инженерүүдийг бэлтгэх цаг үеийн хэрэгцээ шаардлага, тухайн үеийн МАХН-ын Төв хорооны Аж үйлдвэрийн хэлтсийн санал

чиглүүлэлт, МУИС-ийн ректор, академич Н.Содном, ПДС-ийн захирал Б.Лувсанцэрэн, хичээл ангийн эрхлэгч С.Дашдаваа, ГУУФ-ын декан Я.Болд, Уул уурхайн тэнхмийн эрхлэгч Б.Ишмэнд нар Өрмийн хичээл заалгахаар хөөцөлдөн мөхөс намайг багш болгох гэсэн сайхан сэтгэл гаргаж, их итгэл өгч, би өөрөө ч бас хөдөө явахгүй гэсэндээ ч биш, эрдэм номд илүү ойр байх гэсэн, бас багш болох хүсэл мөрөөдөлдөө хөтөлгөдөн хөх ногооны униар татсан тэр л сайхан хавар багшлах ажлын маань зам мөр эхэлж, хэн бүрт үл тохиох багш хэмээх нандин алдрыг сонсох хувь завшаан тохиосон юм.

Энэ л цаг үеэс эргэх дөрвөн улирал 47 удаа давтагдан эх орны эрдэс баялгийн салбарын хамгийн чухал, хамгийн нандин, хамгийн хариуцлагатай үйлс болох мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх эрхэм үйлст тасралтгүй, тууштай ажилласаар өдийг хүрчээ. Энэ замналын маань онцлог бол хувь заяаны хөтөлгөөгөөр эрдэс баялгийн салбарын бүхий л мэргэжлүүд, тухайлбал, геологи-хайгуул, гидрогеологи-усны аж ахуй, геофизик, уул уурхай, өрөмдлөг, газрын тос, хий гээд олон мэргэжлийн сургалт-судалгааны ажилд оролцож, үүгээр ч зогсохгүй хайгуулын өрөмдлөгийн, газрын тосны

өрөмдлөг, олборлолт, боловсруулалт, хадгалалт-тээвэрлэлт, барилга-байгууламж, хийн хангамж-дамжуулалтын зэрэг хэд хэдэн мэргэжлийг цоо шинээр нээн, сургалтын төлөвлөгөө, мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөрүүд, ном сурах бичиг, гарын авлага, сургалт- арга зүйн материалуудыг бэлтгэх, багшлах боловсон хүчнийг бүрдүүлэх, төлөвшүүлэх, сургалт-судалгааны материаллаг баазыг бий болгох, бэхжүүлэх талаар зам мөр гаргаж, анхдагч байж, цаг наргүй хөдөлмөрлөж, чамгүй бас нилээдийг бүтээж ирсэн нь амьдралын маань бахархал, төр түмний маань үнэлэмж болж байдаг юм.

Хүсэл мөрөөдөлдөө хөтөлгөж, итгэл сэтгэлээ өгөн, хүч чадлаа дайчлан ажиллаж ирсэн хөдөлмөр бүтээл, хичээл зүтгэлийг маань төр засаг, түмэн олон, сургууль хамт олноос маань өндрөөр үнэлж мөхөс надад Монгол улсын Боловсрол, Шинжлэх ухаан, Геологи, Уул уурхай, Усны аж ахуй, Газрын тосны зэрэг 6 салбарын Тэргүүний ажилтан цол тэмдэг олгож, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн болон Алтан гадас одонгууд, ойн медалиудаар шагнаж урамшуулсанд миний бие, манай гэр бүл, үр хүүхэд, шавь нар маань их баяртай байдаг.



МУИС-д багш болов, 1975-6-16, тушаал №400

Аливаа юманд анхдагч байх амаргүй, миний унаган мэргэжил уулын инженер-өрөмдөгч, удаах мэргэжил газрын тос, хийн улмаар багш гэсэн нийтлэг нандин, эрхэм хүндтэй мэргэжлийг эзэмших, эзэн нь байхын тулд хоёргүй сэтгэлээр

зүтгэж ирсэн юм.

Бүхэлдээ эх орны анхны Их сургуульд багшаар ажиллаж байснаа энэ сургуультай холбогдсон миний амьдралын нэгэн хэсэг гэж үзэж, одоо ч үргэлжилж байгаагаар төсөөлж, их хувь заяа

гэж сүсэглэж явдаг бөгөөд 80 жилийн түүхт ой нь энэ 2022 онд тохиож байгаа МУИС-ийнхандаа эрүүл энх, саруул сайхан, эрдэм оюуны их амжилт ерөөж байна.

ШУТИС-ийн тэргүүлэх профессор,
Монгол улсын гавъяат багш Жамбын
Цэвээнжав
2022-8-8